



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/560

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "А" дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 61 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар /COVID-19/ -ын цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээний үйл ажиллагаанд Эрүүл мэндийн даатгалын төлбөр тооцоог нэвтрүүлэхтэй холбоотойгоор аймгийн Эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай компьютер олгох, худалдан авах, нийлүүлэхтэй холбоотой ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Т.Дэлгэрсайхан - Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд: Б.Даваадорж - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Ч.Эрдэнэбат - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль эрх зүйн хэлтсийн ахлах
Мэргэжилтэн

Х.Дэмид - Аймгийн худалдан авах ажиллагааны
албаны мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга Л.Батгэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Эрүүл мэндийн байгууллагуудад компьютер олгох, худалдан авах, хүлээлгэж өгөхтэй холбоотой ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалтын дагуу шууд гэрээ байгуулж, худалдан авах ажлыг шуурхай зохион байгуулж хэрэгжилтийг хангуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, ажлын хэсгийн ахлагч Т.Дэлгэрсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

D/Zah-A/560-Bo